



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2009 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 138

Арвайхээр

**Г Архивын баримт бүрдүүлэх арга
хэмжээний тухай**

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 1.6, "Архивын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 5.1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, аймгийн удирдлагууд болон төрийн өндөрлөгүүд оролцсон албан ёсны баяр ёслолын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдал, удирдан зохион байгуулсан хурал зөвлөгөөн, цуглааны ажиллагаа, гадаадын зочин төлөөлөгч хүлээн авсан, аймгийн удирдлагын зүгээс гадаадын байгууллага хүмүүстэй уулзсан уулзалт, үйл явдлын товчоон, аймаг орон нутгийг хамарсан онцгой үзэгдэл зэргийг тухайн үед нь бүрэн баримтжуулан авч төрийн архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулж байхыг холбогдох төрийн байгууллага, комисс, салбар нэгжийн удирдлагад үүрэг болгосугай.

Хоёр. Орон нутагт ажиллаж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудын дээрх үйл явдлыг нээн харуулан гэрэл зураг, дуу авиа, кино дүрс бичлэгээр архивын нэгж бүрдүүлэн зохих зөврийн дагуу хадгалж, төрийн архивт шилжүүлэх талаар гэрээнд тусган ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Д.Баяртогтох/-т даалгасугай.

Гурав. Аймаг орон нутгийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтны ажлыг хүлээлцэх, албаас зохион байгуулж буй тэмдэглэлт үйл явдал, ойн баярын үйл ажиллагааг зохион байгуулах комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд архивын мэргэжлийн ажилтны оролцуулж байхыг аймгийн Засаг даргын орлогч /О.Батжаргал/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Тус захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Архивын тасаг /Ц.Нэргүй/-т үүрэг болгосугай.



Д.ТОГТОХСҮРЭН